

БАТЛАВ:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБААТАР

2022... оны 04... дүгээр сарын 18

УДИРДАМЖ

2022 оны 04 дүгээр сарын 18

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,  
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд  
хяналт-шинжилгээ хийх, ажлын үр дүнг  
үнэлэх тухай

**Зорилго:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал"-ын дагуу бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд хяналт-шинжилгээ хийж, зөвлөгөө өгөх

**Хугацаа:** 2022 оны 04 дүгээр сарын 19

**Ажиллах багийн бүрэлдэхүүн:**

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Уянга	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн

**Хамрах хүрээ:** Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын дарга, мэргэжилтнүүд хамрагдана.

**Хяналт- шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилт
2. Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
3. Байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хоорондын уялдаа

4. Төрийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал
  5. Аймгийн Засаг даргын “Байгууллагын үйлчилгээний стандартын загвар батлах тухай” 2021 оны А/11, “Журам батлах тухай” А/168, Хяналтын хуудас хэрэглэх журам батлах тухай” А/340 дүгээр захирамжийн хэрэгжилттэй танилцах
  6. Төрийн мэдээлэл солилцооны систем болон Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн хэрэгжилттэй танилцах
  7. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
  8. Мэдээллийн ил тод байдал
- Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэн үнэлгээ өгнө.
  - Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.
  - Хяналт-шинжилгээний дүнг удирдлагын зөвлөлд ажлын 7 хоногт багтаан танилцуулна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
АГЕНТЛАГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.УЯНГА

